

UCS0002-02:2019

ГАДНА ОРЧНЫ ТОХИЖИЛТ



Хүүхдийн тоглоомын талбайн эрүүл, аюулгүй орчныг
бүрдүүлэхэд тавигдах ерөнхий шаардлага

ГАДНА ОРЧНЫ ТОХИЖИЛТ

Хүүхдийн тоглоомын талбайн эрүүл, аюулгүй орчныг
бүрдүүлэхэд тавигдах ерөнхий шаардлага



Улаанбаатар хот
2019 он

ГАРЧИГ

БҮЛЭГ 1. ҮНДСЭН ОЙЛГОЛТ.....	3
Зорилго.....	3
Хамрах хүрээ.....	3
Норматив ишлэл.....	3
Нэр томъёоны тайлбар.....	3
БҮЛЭГ 2. ТОГЛООМЫН ТАЛБАЙ. ЕРӨНХИЙ ШААРДЛАГА.....	5
Тоглоомын талбайн байршил.....	5
Тоглоомын талбайн бүтэц.....	6
Тоглоомыг сонгох нь.....	7
Тоглоомын талбайн гадаргуу.....	9
Тоглоомын материал.....	10
Тоглоомыг угсрах ба суурилуулах.....	11
БҮЛЭГ 3. ТОГЛООМЫН ТАЛБАЙД ТОХИОЛДОХ МАГАДЛАЛ БҮХИЙ АЮУЛ, ЭРСДЭЛ.....	12
Мөргөлдөх, шүргэлдэх эрсдэл.....	12
Орооцолдох, гогодох эрсдэл.....	12
Уяа.....	13
Толгой тээглэх эрсдэл.....	13
Завсар зай.....	14
Хурц өнцөг, булан, ирмэгээс учрах эрсдэл.....	14
Орооцолдох эрсдэл.....	14
Тэнцвэр алдах эрсдэл.....	14
Хуучин дугуй.....	15
Чөлөөт уналтын өндөр.....	15
БҮЛЭГ 4. АШИГЛАЛТ, АРЧИЛГАА ҮЙЛЧИЛГЭЭ.....	16
Засвар үйлчилгээний хяналт.....	16
Засвар.....	16
Элэгдсэн гадаргуугийн засвар.....	16
БҮЛЭГ 5. ТОГЛООМЫН ТАЛБАЙН ИЖ БҮРДЭЛ.....	17
Тавцан, бариул, хамгаалалтын хашлага.....	17
Тоглоомын оролтын хэсэг (Access method).....	17
Тоглоомын үндсэн төрлүүд.....	20
Ашиглалтын бус.....	22
ХАВСРАЛТ 1.....	27
ХАВСРАЛТ 2.....	28

БҮЛЭГ 1. ҮНДСЭН ОЙЛГОЛТ

Зорилго

Энэхүү эмхэтгэлийн зорилго нь бага насны хүүхдийн бие бялдрыг чийрэгжүүлэх, амралт, чөлөөт цагийг зөв зохистой өнгөрүүлэхэд чиглэгдсэн гадна тоглоомын талбайн эрүүл, аюулгүй таатай орчныг бүрдүүлэхэд тавих ерөнхий шаардлагыг тогтооход оршино.

Хамрах хүрээ

Эмхэтгэлд Монгол улсад хүчин төгөлдөр мөрдөж буй стандартыг баримталсан бөгөөд нийтийн эзэмшлийн газар, цэцэрлэг, сургууль, орон сууцны хорооллын эдэлбэр газарт байрлах 6 сартайгаас 12 нас хүртэлх хүүхдийн тоглоомын талбайн эрүүл ахуйн орчин, аюулгүй байдлыг хангуулах, осол гэмтлээс урьдчилан сэргийлэх, түүнд хяналт тавихад хамаарна.

Норматив эшлэл

Эмхэтгэлд олон улсын болон Монгол улсын хэмжээнд баримталж буй дараах бодлогын болон норм, нормативын баримт бичгүүдэд суурилсан бөгөөд тухайн баримт бичигт өөрчлөлт орсон тохиолдолд хамгийн сүүлчийн албан ёсны эх материалыг баримтална.

- 1.1. Хүүхдийн тоглоомын талбай. MNS 6751:2019
- 1.2. Тоглоомын аюулгүй байдал. 3-р хэсэг: Зарим элементийн шилжилт MNS ISO 8124-3:2011.
- 1.3. Тоглоомын аюулгүй байдал. 4-р хэсэг: Орон сууцны дотор, гадна талд байрлуулан хэрэглэдэг савлуур, гулсуур болон түүнтэй төсөөтэй тоглоомын ажиллагаа
- 1.4. БНБД 30.01.03, Хот, тосгоны төлөвлөлт барилгажилтын норм ба дүрэм
- 1.5. БНБД 31.03.03*/11 Олон нийтийн иргэний барилга

Нэр томъёоны тайлбар

Хүүхдийн тоглоомын талбай: Хүүхэд бие бялдраа хөгжүүлэх, чөлөөт цагийг зөв зохистой өнгөрүүлэх, тоглох зориулалт бүхий талбай.

Хамгаалалтын гадаргуу: Тоглоомын ашиглалтын бүсийн гадаргуу бөгөөд хүүхэд тоног төхөөрөмжөөс чөлөөт уналт хийхэд үүссэн хүчийг сааруулах, багасгах гадаргуугийн материал. 2,4 шаардлагыг хангасан байх ёстой.

Дундрах-дүүргэх гадаргын материал:

Тоглоомын ашиглалтын бүсэд хамгаалалтын гадаргуу болгон хэрэглэгддэг элс, хайрга, боловсруулсан модон материал, хэрчсэн резин гэх мэт ашиглалтын явцад тарж дундардаг нөхөх шаардлагатай материал.

Чөлөөт талбай: Хөдөлгөөнт тоглоомын дээр, дотор, эргэн тойрны талбай нь савлуур, гулсуур, эргэдэг тоглоомын хүчтэй хөдөлгөөнд тохирсон байх шаардлагатай талбай;

Хязгаарлалтын бүс: Аюулгүй байдлыг хангах зорилгоор тоглоомын талбайг зориулалтын бусаар (явган хүний зам, зорчих хэсэг) ашиглахаас тусгаарласан бүс

Түлхэх талбай: MNS ISO 8124:2011 стандартын 6.4-д заасны дагуу түлхэх хүчний сорил хийх үед сорилын биетэй савлуурын элемент хүрэлцэх талбай.

Хүчилсэн хөдөлгөөн: хүүхдийн хийж буй хөдөлгөөний чигт болон илүү урт замд хөдлөх хөдөлгөөн нь савлуур, гулсуур, савладаг болон эргэдэг тоглоомын ажиллагаагаар тодорхойлогдох хөдөлгөөн;

Чөлөөт уналтын өндөр: тоглоомын төхөөрөмжийн хамгийн дээд хэсгийн тоглох зориулалттай гадаргуун цэг ба түүний доорх хамгаалалтын гадаргуугийн хоорондох босоо зай.

Тоглох зориулалтын гадаргуу: Зогсож, алхах, мөлхөх, суух, авирах зориулалттай тоглоомын төхөөрөмжийн гадаргуу бөгөөд 30 градусаас бага налуутай, эргэн тойрон 2 инчээс багагүй хэмжээтэй байна.

Суурилуулах: Тоглоомыг газрын гадаргууд бэхлэх, тогтоох.

Хянагч: Тоглоомын талбай дээр тоглож байгаа хүүхдүүдийг хянах үүрэгтэй хүн. Удирдах ажилтнууд, цалинтай мэргэжлийн хүмүүс (жишээ нь, хүүхэд асрагч, бага сургууль, цэцэрлэгийн ажилтнууд), цалинтай улирлын ажилчид (жишээ нь, коллеж эсвэл ахлах сургуулийн оюутнууд), сайн дурынхан (жишээ нь, РТА гишүүд), эсвэл цалингүй асран хүмүүжүүлэгчид (жишээ нь эцэг, эх)

Бага насны хүүхэд: 06 сараас 23 сар хүртэлх насны хүүхдүүд

Сургуулийн өмнөх насны хүүхэд: 2 - 5 нас хүртэлх насны хүүхэд

Сургуулийн насны хүүхэд: 5-12 нас хүртэлх насны хүүхэд

Хаалт, хашлага: Газраас дээш өргөгдсөн гадаргын хязгаарлалтын хэрэгсэл бөгөөд хүүхэд тоглоомын төхөөрөмж дундуур санаатай болон санамсаргүй нэвтрэхээс хамгаалах зориулалттай.

Бариул: Газраас дээш өргөгдсөн гадаргын хязгаарлалтын хэрэгсэл бөгөөд хүүхэд өндрөөс санамсаргүй унахаас хамгаалах, биеийн тэнцвэрээ хадгалж зогсоход туслах зориулалттай.

Сараалж: Хамгаалалтын бариул болон тавцангийн хооронд завсраар хүүхэд нэтрэхээс хамгаалсан материал. (Босоо багана, тор, хатуу самбар г.м)

Холбох тавцан: Тоглоомын эхний хэсгийг бусад хэсгүүдтэй нь холбох эсвэл бусад хэсгүүдээр дамжин явах тавцан.

Хавтгай Тавцан: Хүүхэд дээр нь тоглох эсвэл нэг газраас нөгөө газарт шилжихэд хэрэглэгддэг дээш өргөгдсөн, хөндлөн гадаргуу;

ТАЙЛБАР: Гулсуурын эхлэх хэсгийн 129000 мм²-аас бага талбайг тавцанд тооцохгүй.

Хөндлөвч: Тоглоомын гол ачаалал хэсгийг тулах зориулалттай, бөөрөнхий эсвэл савхан хэлбэртэй хэрэгсэл.

Унжлага холбоос: Хөндлөвч мод савлууур хоёрыг хооронд нь холбох хэрэгсэл.

Савлууур: Өлгөх болон холбож өлгөх аргаар савлуурыг савлуурын элементтэй болон хөндлөвчтэй холбож уях зориулалттай бүтэц.

Нийлмэл бүтэц: 2-оос дээш төрлийн тоглоомын бүтцийг хавсарган холбож өгсөн олон төрлийн тоглоом тоглох боломжтой нийлмэл бүтэцтэй төхөөрөмж.

ТАЙЛБАР: Чөлөөт талбай гэсэн тодорхойлолтод уналтын хөдөлгөөн хийдэг

тоглоомын 3 хэмжээст талбай хамаарахгүй болно.

Гулсуур: тодорхой замаар гулсахад зориулагдсан налуу гадаргуу (3-р зураг); ТАЙЛБАР: Дээвэр, налуу гарц зэрэг өөр зориулалтаар ашиглах бусад налуу гадаргууг гулсуурт хамруулаагүй болно

Далангийн гулсуур: Энэ гулсуур нь газрын контурыг дагасан хэлбэртэй, гулсуурын аль ч цэг нь газраас 12 инчээс дээш зайтай байх ёстой.

Битүү хаалттай савлууур: 4-өөс бага насны хүүхдэд зориулагдсан эргэн тойрон битүү хамгаалалтын хаалттай, хөлийн хооронд бэхэлгээтэй, асран хамгаалагчийн тусламжтай бууж суух зориулалттай савлууур ТАЙЛБАР: Суудлын эргэн тойрон битүү хаалттай савлуураар савлахад хаалт болон хөлийн хоорондох бэхэлгээ нь хүүхдийн биеийн бүх талаас түших тулгуурын үүрэг гүйцэтгэдэг.

Битүү туннелийн гулсуур: Гулсах замыг бүхэлд нь багтаасан хаалттай хоолой эсвэл хонгилон гулсуур.

Биеийн дээд хэсгийн дасгалын төхөөрөмж: Хүүхдийн зөвхөн гар оролцсон тоног төхөөрөмж (жишээ нь хэвтээ шат, дүүжин цагаригууд г.м.)

Орооцолдох: Хүүхдийн хувцас болон хүзүү орчмын аливаа зүйл тоглоомын бүтцийн элементүүдэд тээглэж эсвэл орооцолдож гацсан аюултай нөхцөл байдал.

Гацах: Тоглоомын бүтцийн онгорхой хэсгээр нэвтрэх үед бие болон биеийн хэсгийг гаргаж авахад хүндрэл үзүүлж буй нөхцөл байдал.

БҮЛЭГ 2. ТОГЛООМЫН ТАЛБАЙ. ЕРӨНХИЙ ШААРДЛАГА

Тоглоомын талбайн байршил

Тоглоомын талбайн байршлыг сонгохдоо дараах хүчин зүйлсийг анхаарч үзэх шаардлагатай.

Хүчин зүйл	Асуулт	Авах арга хэмжээ
Хүүхдүүд тоглоомын талбайд ирэх замын төлөв байдал	Ямар нэг эрсдэл байна уу?	Эрсдэлийг арилгах
Эргэн тойронд эрсдэл учруулж болох зүйлс бий эсэх (авто зам, нуур, цөөрөм, гуу жалга, хад асга)	Хүүхэд санамсаргүйгээр эрсдэлтэй газар руу очих боломжтой юу? Бага насны хүүхэд аюултай газар руу мөлхөж очих боломжтой байна уу?	Хүүхдийг тоглоомын талбай дотор байлгах арга хэмжээ авах. Жишээлбэл: шигүү бут сөөг(ногоон хашаа) эсвэл хашаа. Асран хамгаалагч нь хүүхдийг харж хандах боломж олгох ёстой. Хашаа нь стандартын шаардлага хангах ёстой.
Нарны нөлөө	Ил гарсан металл гулсуур, тавцан, шатны гадаргуу нь нарны нөлөөгөөр халж хүүхдийг түлж гэмтээхээр хэмжээнд халж байна уу?	Ил гарсан металл гулсуур, тавцан, шатны гадаргуу нь нарны шууд тусгал тусахааргүй сүүдэрлэгдсэн байна. Гадаргуу нарны нөлөөнд халсан байх боломжтой тухай санамж байрлуулсан байна.
	Хүүхэд өдрийн наранд хэт халах, наранд цохиулахаар байна уу?	Тоглоомын талбайд сүүдрэвч байрлуулна. 06 сараас 23 сартай хүүхдийн элсэн тоглоомын хэсэгт заавал нарны тусгалаас хамгаалсан сүүдрэвч байна.
Газрын гадарга ба ус зайлуулах шугам	Гадаргуугийн хучилтын материал нь борооны усыг зайлуулж байна уу?	Тохиромжтой ус зайлуулах арга хэмжээ авах.
Тохижилт	Тоглоомын талбай нь нэгдсэн хог хаях цэгээс 100 метрээс багагүй зайтай байна уу?	Нэгдсэн хогийн цэгийг тоглоомын талбайгаас 100 метрээс багагүй зайд байрлуулах
	Тоглоомын талбайд ахуйн хогийг ялган хаях савыг хүрэлцэхүйц хэмжээгээр (багадаа 2 ширхэг) салхины зонхилох чиглэлийн доор байрлуулсан байна уу?	Хогийн савыг шаардлагын дагуу байрлуулах.
	Тоглоомын талбайн 20-с багагүй хувьд ногоон байгууламж байна уу.	Ногоон байгууламж бут сөөг тарих.

Аюулгүй байдал	Тоглоомын талбайн хязгаарлах бүсийн хилээс тээврийн хэрэгслийн зам хүртэлх зай 6 метрээс ихгүй байна уу?	6 метрээс ихгүй тохиолдолд хурд сааруулагч суурилуулж, “хүүхэд” тэмдэглэгээ бүхий анхааруулах тэмдгийг жолоочид харагдах газар байрлуулна.
	Хүйтний улиралд тоглоомын талбайг халтиргаа гулгаанаас хамгаалсан байна уу?	Анхааруулах тэмдэг тэмдэглэгээ байрлуулах, цас мөсийг цэвэрлэх
	Онцгой байдлын үед аюул ослоос зайлж гарах орц гарц, хэрэгсэл байна уу?	2-оос доошгүй орц гарцтай байна. Гал унтраах анхан шатны хэрэгслийг харуулын цэг дээр байрлуулна.
	Хүүхдийн тоглоомын талбайн бүсийн хил нь цахилгаан дамжуулах агаарын шугамын доор, газар доорх цахилгаан дамжуулах кабель, дулааны сүлжээний худаг, дамжуулах хоолойн дээр, инженерийн хангамжийн үзлэгийн болон хяналт, тохируулгын худагас зохих зайд байна уу?	5 метрээс багагүй зайд тоглоомын талбайг тохижуулна.
Талбайн хэмжээ	Талбайн хэмжээ насны онцлогт тохирсон шаардлагыг хангасан байна уу?	06 сараас 23 сартай хүүхдийн тоглоомын талбай 50 м ² -аас их, 2-оос 5 настай хүүхдийн тоглоомын талбай 100 м ² -аас их талбайтай байна.

Тоглоомын талбайн бүтэц

Тоглоомын талбайн бүтцэд дараах үндсэн хүчин зүйлд анхаарах хэрэгтэй.

- Хүртээмжтэй байдал
- Насны ангилал
- Зөрчилдөөнтэй үйлдэл
- Ажиглах, харж хандах боломж
- Санамж болон мэдээлэх тэмдэг
- Хяналт

Хүртээмжтэй байдал

Хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд тоглох стандартын шаардлагыг хангасан орчныг тоглоомын талбайд бүрдүүлсэн байна.

Насны ангилал

Тоглоомын талбайг хүүхдийн бие бялдар, насны ангиллаар “Бага насны хүүхэд” буюу 06 сараас 23 сар хүртэлх насны хүүхдүүд, “Сургуулийн өмнөх насны хүүхэд” буюу 2 - 5 нас хүртэлх насны хүүхэд, “Сургуулийн насны хүүхэд” буюу 5-12 нас хүртэлх насны хүүхдийн

гэж ангилна.

Хүүхдийн тоглоомын талбайд тоглоомыг насны ангиллаар хуваарилан суурилуулж, бут сөөг, сандал зэргээр зааглагдах хэрэгтэй. Энэ нь хурдтай гүйж байгаа том хүүхдүүд жижиг хүүхдийн талбайд ороход хөдөлгөөний хурдыг багасгаж хүүхэд бэртэж гэмтэх эрсдэлийг бууруулдаг.

Зөрчилдөөнтэй үйлдэл

Тоглоом хооронд гүйх хүүхдүүдийн хөдөлгөөн болон зөрчилдөөнтэй үйлдлээс гарч болох гэмтэл бэртлээс урьдчилан сэргийлэхийн тулд тоглоом нь тоглоомын төрлөөс хамааран өөр өөр хэсэгт хуваарилагдсан байх хэрэгтэй. Идэвхтэй хөдөлгөөнтэй тоглоомууд нь илүү тайван эсвэл чимээгүй тоглоомоос тусдаа байх шаардлагатай. Тоглоомын талбай, задгай талбай, элсэн талбай зэрэг нь тоглоомын талбайн өөр өөр хэсэгт байрлах хэрэгтэй.

Тоглоомууд төрлөөсөө хамаараад өөр өөр ашиглалтын бүстэй байна. Тоглоомын талбайд тоглоом байршуулах ерөнхий шаардлагыг доор дурдав.

- Савлуур, эргэдэг тавцан нь тоглоомын талбайн булан, зах хэсгээр байрлах тохиромжтой.
- Гулсуурын төгсгөл хэсэгт бөөгнөрөл үүсэхээргүй байх ёстой бөгөөд тоглоомын талбайн сийрэг хэсэгт байрлана.
- Нийлмэл бүтэцтэй тоглоом өргөн хэрэглэгдэж байгаа бөгөөд ийм тоглоомын хэсгүүд харилцан бие биетэйгээ уялдсан байна. Жишээ нь: тоглоом руу орох хэсэг нь гулсуурын төгсгөл хэсэгт байж болохгүй.

Ажиглах, харж хандах боломж

Хэдийгээр тоглоомын талбай нь аюулгүй ажиллагааны заавар стандартаар бүтээгдэж, суурилуулагдаж, ашиглагдаж байгаа ч хүүхдэд эрсдэл учруулах боломжтой байдаг. Иймд тоглоомын талбайд эцэг эх, асран хамгаалагчид хүүхдээ харж хандах тоглоомын талбайн орчинд нэвтрэх боломжтой байх шаардлагатай. Хүүхэд харагдах боломжийг хамгийн сайн байлгах хэрэгтэй.

Жишээ нь: Цэцэрлэгт хүрээлэнд тоглоомын талбай нь цэцэрлэгт хүрээлэнгийн амрах сандлаас маш сайн харагддаг байх хэрэгтэй. Мөн түүнчлэн хүүхдийн тоглоомын талбайд олон хүүхэд харж байгаа асран хамгаалагч бага насны хүүхдийн талбайгаас том хүүхдийн талбайд тоглож буй хүүхдээ харах боломжтой байх хэрэгтэй.

Хүүхдийн асран хамгаалагч хүүхдээ тодорхой зайнаас харах, суух, амрах зориулалт бүхий суудалтай байна.

Харуул хамгаалалтын цэгээс 10 метрийн радиуст байрлах ба тоглоомын талбайг камержуулсан байна.

Санамж болон мэдээлэх тэмдэг

Тоглоомын загвар болоод хамрах хүрээний талаар мэдээллийг тоглоомын талбайн орчинд (орц, гарц) болон тоглоомын дээр байрлуулсан байна. Санамж болон мэдээлэх тэмдэг нь асран хамгаалагч нарт тоглоомыг хэрхэн тоглох болон хэдэн настай хүүхэд тоглоход тохиромжтой талаар зааварчилгааны мэдээлэл өгсөн байна.

Тоглоомын талбайн мэдээлэх тэмдэгт уг тоглоомын талбайн хариуцсан байгууллагын нэр, холбоо барих утас зэрэг мэдээллийг тусгасан байна.

Хяналт

Жишээ нь: Хүүхэд асрагч, бага сургууль эсвэл цэцэрлэгт хүрээлэнгийн арчлалт хариуцсан хүн, улирлын чанартай гэрээт ажилчин (ахлах ангийн сурагч болон оюутан), сайн дурын ажилтан, эцэг эх гэх мэт.

Бүх төрлийн хүүхдийн тоглоом нь аль ч насны хүүхдэд тохиромжтой биш бөгөөд хүүхдүүд насны онцлогтоо тохирсон тоглоомоор тоглох нь эрсдэлгүй гэдгийг эцэг эх болон талбайн хянагч нар ойлгосон байх хэрэгтэй.

Эцэг эх, асран хамгаалагч нь хүүхдийг тоглуулахаас өмнө тоглоомын талбайн мэдээлэх тэмдгээс мэдээлэл авсан байх шаардлагатай бөгөөд хүүхдээ тоглуулахаас өмнө тоглоомын талбайг шалгаж тоглоомын тоног төхөөрөмж эвдэрсэн эсэхийг шалгаж, хүүхэд гацах, хувцсаараа гогодох, гэмтэх зүйлүүдийг аюулгүй болгох, урьдчилан сэргийлж тоглоомын талбайн гадаргууд хурц ирмэгтэй, хагарсан шил зэрэг зүйлүүд байвал зайлуулсны дараа хүүхдээ тоглуулах хэрэгтэй.

Хүүхдээ насны онцлогт нь тохирсон тоглоом дээр тоглуулах, тоглож байх үед тасралтгүй анхаарал халамжтай байх ёстой. Энэ нь бага насны хүүхдэд илүү хамаарна.

Шаардлагатай тохиолдолд тоглоомын талбайн ашиглагчид тоглоомын ашиглалт, эвдрэл гэмтэлтэй холбоотой мэдээллийг мэдээлэх тэмдэгт байгаа хаяг, утасны дугаараар мэдэгдэнэ.

Тоглоомыг сонгох нь

Хүүхэд нас насны онцлогоосоо хамаараад аливаа зүйлийг хийх чадамж нь өөр өөр байдаг. Хүүхдийн тоглоом нь хүүхдийн бие бялдрыг хөгжүүлэх, шинэ чадвар эзэмшүүлэхээр хийгдсэн байдаг ч хүүхдийн хэмжээ, чадвар, хөгжлийн түвшинд таарсан байх хэрэгтэй. Иймд хүүхдийн тоглоомыг сонгохдоо хэдэн насны хүүхдэд зориулж байгааг чухалчлан үзнэ.

Мөн тухайн тоглоомыг хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд тоглох боломжтой байх ёстой. Хүснэгт 1-д хүүхдийн тоглоомыг насны ангиллаар жишээ болгон үзүүлэв.

Хүснэгт 1. Хүүхдийн тоглоом: Насны ангиллаар

06-23 сартай	2-5 настай	5-12 настай
		
<ul style="list-style-type: none"> • Авирдаг тоглоом 80 см-аас бага өндөртэй • Налуу хавтан • Энгийн жижиг шат • Гулсуур* • 360⁰-с бага өнцгөөр эргэх спираль хэлбэрийн гулсуур • Пүрштэй савлуур • Шаталсан зам • Хамгаалалттай савлуур 	<ul style="list-style-type: none"> • Авирдаг тоглоом** • Хөндлөн дамнуурга 150 см-аас бага, 4-5 настай хүүхдэд 150 см-аас өндөр байж болно • Гүйдэг бөмбөрцөг • Налуу хавтан • Эвхэгддэг шат • Энгийн жижиг шат • Гулсуур* • 3600-с хүртэл өнцгөөр эргэх спираль хэлбэрийн гулсуур • Пүрштэй савлуур • Шаталсан зам • Хамгаалалттай савлуур (2-4 настай) болон эргэлддэг дугуй 	<ul style="list-style-type: none"> • Нуман хэлбэрийн авирдаг шат • Гинжин болон олсон дүүжин шат, гүүр • Босоо авирдаг шат, уян хэсгүүдтэй • Дүүжин даажин • Хөндлөн дамждаг шат, авирдаг шат • Хөндлөн дамждаг цалгираг*** • Эргэдэг тавцан • Налуу хавтан • Гулсуур* • 1-с олон удаа 3600 эргэх спираль хэлбэрийн гулсуур • Шаталсан зам • Савлуур болон эргэдэг дугуй • Дүүжин гулсуур • Босоо гулгах багана

Тоглоомын талбайд хэрэглэхийг хориглох тоглоом



Ойдог тавцан (Trampolines)



Савладаг хаалга.Swinging gate



Том хэмжээний эргэдэг гинж



2 талдаа бэхэлгээгүй авирдаг олс

- Хүнд төмөр савлуур
- Олноороо суудаг савлуур
- 2 талдаа бэхэлгээгүй авирдаг олс
- Олсон савлуур гэх мэт хүүхдэд гэмтэл учруулж болохуйц тоглоомуудыг суурилуулахыг хориглоно.

Тоглоомын талбайн гадаргуу

Хүүхдийн тоглоомын талбайн гадаргуу чөлөөт уналтын өндөр болон тоглоомын төрлөөс хамааран хүүхдэд гэмтэл учруулахааргүй байна.

Чөлөөт уналтын өндрөөс хамаарсан материалын төрөл болон зузааны жишиг хэмжээг хүснэгт 2-т үзүүлэв.

Хүснэгт 2. Гадаргуугийн материал болон зузаан

Чөлөөт уналтын өндөр (м)	Гадаргуугийн материалын төрөл	Гадаргуугийн материалын зузаан (мм)
3.00	Хэрчсэн/Дахин боловсруулсан резин	150
1.20	Элс	220
1.50	Хайрга	220

Хүүхдийн тоглоомын талбайн гадаргуу нь хүүхэд тээгэлдэх бүдрэхээргүй тэгш, цэвэрлэхэд хялбар, хур тунадас тогтохооргүй, хурц ирмэггүй, гогцоогүй байна (Хүснэгт 3).

Хүснэгт 3. Тохиромжтой болон тохиромжгүй гадаргуугийн материал

Тохиромжтой гадаргуу	Тохиромжгүй гадаргуу
	
<ul style="list-style-type: none"> • Хайрга • Элс • Хэрчсэн/Дахин боловсруулсан резин 	<ul style="list-style-type: none"> • Асфальт • Хивсэнцэр • Цемент • Шороо • Зүлэг

Хүүхдийн тоглоомын талбайн гадаргууг хүүхэд тоглоомын тоног төхөөрөмжөөс унахад чөлөөт уналтаас үүссэн хүчийг сааруулах багасгах зорилгоор хөвсгөр резин (нягт нь 20 кг/м³ -ээс ихгүй), элс, голын хайрга, дахин боловсруулсан резин, резин хавтанцар, хиймэл зүлэг зэргийг талбайн гадаргууд хэрэглэнэ.

Тоглоомын талбайн гадаргууг бетон, асфальт зэрэг хатуу ирмэгтэй, арзгар гадаргуугаар хийхийг хориглоно.

Гадаргууг хромоор нэвчүүлсэн мод, модны зомгол, хүүхэд амархан бохирдох гадаргуугаар хийхийг хориглох бөгөөд зүлгээр хийхийг олон улсад зөвлөдөггүй.


Хүснэгт 4. Хүүхдийн тоглоомын талбайн гадаргуугийн зузааны зохистой хэмжээ

Гадаргуугийн материал	Зузааны хэмжээ /мм/	Чөлөөт уналтын өндөр /мм/
Элс	150	1500
	225	1500
	300	2700
Хайрга	150	1800
	225	2100
	300	3000
Модны холтос	150	1800
	225	2100
	300	3600

Хүснэгт 5. Дундрах-дүүргэх гадаргын материалын хучилтын хамгийн бага зузаан

Зузаан /мм/	Дундрах-дүүргэх гадаргын материал	Чөлөөт уналтын өндөр /мм/
150*	Хэрчсэн/дахин боловсруулсан резин	3000
230	Элс	120
230	Хайрга	150
230	Модны холтос	3000

Хүүхдийн тоглоомын талбайн гадаргуугийн байх ёстой бүтэц, үеийг зураг 1-д заасны дагуу хийж гүйцэтгэх ёстой.



Зураг 1. Хүүхдийн тоглоомын талбайн гадаргуугийн байх ёстой бүтэц

Тоглоомын материал

Тоглоомын зааварт “Тоглоомын гадаргуу/ талбайг хийсэн материалын талаарх хэрэглэгчид хүргэх мэдээлэл”-ийг тусгасан байх шаардлагатай.

Эдэлгээ

Чанарын шаардлага хангасан материалаар хийгдсэн, эдэлгээ даах тоглоомыг сонгох.

Хийц

Үйлдвэрлэгчийн зааврын дагуу тоглоомыг угсарна.

Түгжээ, холбогч, хамгаалалтын бүрээс зэрэг нь бүрэн бүтэн, тусгай багаж хэрэглэхгүйгээр тайлж авах боломжгүй байна.

Түгжээ, холбогч, хамгаалалтын бүрээс зэрэг нь ураг, хатгах, хувцас тээглэх эрсдэл учруулахааргүй байна.

Эрэг боолт бусад түгжих бэхлэх зүйлс нь сулрах болон тайлагдахаас хамгаалагдсан байна.

Хөдөлгөөнт холбоосны хийц нь сулрах, мултрахаас хамгаалагдсан байна.

Бүх түгжээснүүд зэврэлтээс хамгаалагдсан байх ба холбосон эд ангийн зэврэлтийг хамгийн бага хэмжээнд байхаар материалыг сонгоно.

Хөдөлгөөнт хэсгийн холхивч болон тээглүүр нь тослоход амархан байх шаардлагатай.

S, C хэлбэрийн болон бүх төрлийн дэгээнүүд битүүлэгдсэн байх шаардлагатай

Металл

Ил төмрөөр тавцан, гулсуур, шат хийхээс татгалзах хэрэгтэй. Нарны шууд тусгалд халж хоромхон хугацаанд түлэх хэмжээний гэмтэл учруулах эрсдэлтэй.

Будаг

Будах, цайрдах болон бусад аргаар төмөр хийцийг зэврэлтээс хамгаална.

Тоглоом үйлдвэрлэгч нь хэрэглэгч тоглоомтой харилцсанаар тоглоомыг будсан, хамгаалсан химийн бодисоос хордохгүй байхыг батлах ёстой.

Будаг нь стандартын шаардлага хангасан байна.

Будсан гадаргуу нь зөв болон элэгдлээс хамгаалагдсан байна.

Мод

Мод нь ялзрах, шавьжид идэгдэх зэрэг элэгдлээс хамгаалагдсан байна. Креозот, пентахлорофенол, Трибутил, цагаан тугалганы исэл, пестицид хэрэглэсэн модыг тоглоомын талбайд хэрэглэхийн хориглоно.

Тоглоомыг угсрах ба суурилуулах

Тоглоом суурилуулах заавар нь түүнийг дагалдах бичиг болон санамжид тодорхой бичигдсэн байна. Заавар нь мэргэжлийн бус хүн ойлгохоор энгийн, товч тодорхой байна.

Тоглоомыг суурилуулахдаа үйлдвэрлэгчийн зааврыг чанд мөрдөнө.

Тоглоомыг угсарсны дараа хэрэглэж эхлэхээс өмнө мэргэжлийн хүнээр аюулгүй ажиллагаа нь хянагдаж баталгаажуулагдана.

Үйлдвэрлэгчийн угсралт суурилуулалтыг заавар бусад холбогдох материалууд байнга хариуцсан байгууллагад хадгалагдаж байх ёстой.

Угсрах, суурилуулах заавар нь дараах мэдээллийг агуулна. Үүнд:

- a) Хөдөлгөөнт тоглоомыг ямар нэгэн байгууламжаас дор хаяж 1,8 м зайд байрлуулах эсвэл хашаа, гараж, байшин, хэц, унжсан салаа мөчир, угаалгын газрын шугам хоолой, цахилгааны утас зэрэгт саад учруулахааргүй газар суурилуулах талаарх зөвлөмж;
- b) Энгийн хэрэглээний үед болон санаандгүй тохиолдлоор буруу хэрэглэх явцад тулгуурын бусад элемент өргөгдөх, бэхэлгээний хэрэгсэл мултарч хөмрөхөөс сэргийлэхийн тулд зангуу, гадас зэрэг бэхэлгээг хэрхэн суурилуулах, хөрсний бүтцийг онцгой анхаарах зэрэг зааврыг нарийвчлан тусгана;
- c) Бүүдрэх, тээгэлдэх аюулыг багасгахын тулд зангуу, гадсыг газартай тэгшлэх эсвэл газарт булах заавар;
- d) Дүүжин даажин, савлуур, гулсуур, авирах хүрээ зэрэг хөдөлгөөнт тоглоомын зааварт элс, хөөс, хаймар, модны холтос, үртэс зэрэг гадаргууд суурилуулахад хэрхэн нөлөөлөх талаар тусгана. Тоглоомыг асфальт, цемент зэрэг аливаа хатуу гадаргууд суурилуулж болохгүй;
- e) Тоглоомыг зөв угсрах зураглал, бүдүүвчийг хавсаргана.


БҮЛЭГ 3. ТОГЛООМЫН ТАЛБАЙД ТОХИОЛДОХ МАГАДЛАЛ БҮХИЙ АЮУЛ, ЭРСДЭЛ

Энэ хэсэгт хүүхдийн тоглоомын талбайн аюулгүй байдлыг хангуулах, осол гэмтлээс урьдчилан сэргийлэх, түүнд хяналт тавих, аюул эрсдэлийн талаар дэлгэрэнгүй мэдээллийг өгч аюул тус бүрээр учирч болох эрсдэлүүдийн талаарх мэдлэгийг дээшлүүлэх зорилготой.

Мөргөлдөх, шүргэлдэх эрсдэл

Тоглоомын талбайд тоглож байгаа хүүхдүүд биеэрээ мөргөлдөх, шүргэлцэхээр нөхцөл байдал огт байж болохгүй. Мөргөлдөх болон шүргэлцэх эрсдэл нь бие биетэйгээ хамааралтай хөдөлдөг эсвэл тогтмол зайгаар эргэлдэх тоглоомын хэсгүүдээс үүсдэг. Жишээ нь: Савлуур, дүүжин даажин, эргэдэг тавцан гэх мэт.

Тоглоом элэгдэж хуучирсан эсвэл буруу суурилуулсан, эрэг боолт гээгдсэнээс



Боолтны тавны диаметр нь суурь болон эргэний диаметрээс их байх нь гогодох эрсдэл учирч болзошгүй аюулын жишээ

Зураг 2. Гогодох эрсдэлийн жишээ

Холбох эд ангийн эхлэл, төгсгөлийн хэмжээ адил байх хэрэгтэй (6-р зураг). Хатуу боолтын суурийн хэмжээ нь боолтын толгой эсвэл эрэг шургын төгсгөл хэсгийн хэмжээгээр тодорхойлогдоно.


Завсар эсвэл V хэлбэрийн нүхтэй үед хэрэглэгч хүчтэй хөдөлгөөнөөр нэвтрэн орохын өмнө эсвэл тоглож эхлэх үед хувцасны хэсэг тээгэлдэж болно.

Гулсуур, гал сөнөөгчийн гадас, дээвэр, гинж, мөлхөө хүүхдийн явах зам зэрэг тоглоомыг MNS ISO 8124-4 : 2011 “Орон сууцны дотор

мөргөлдөх, шүргэлцэхээр нөхцөл үүсдэг. Хариуцсан байгууллага, эцэг эх асран хамгаалагч нар дээрх нөхцөл байдал үүссэн эсэхэд хяналт тавьж осол гэмтэл учрахаас урьдчилан сэргийлнэ.

Орооцолдох, гогодох эрсдэл

Боолтын толгой, эрэг, шураг зэрэг холбох эд ангийн ил харагдах хэсэг нь далдлагдсан эсвэл хамгаалагдсан байна. Энэ нь хэрэглэгчийн хувцас тээгэлдэх, биеийг гэмтээх аюулаас хамгаална. MNS ISO 8124-4 : 2011 “Орон сууцны дотор гадна талд байрлуулан хэрэглэдэг савлуур, гулсуур болон түүнтэй төсөөтэй тоглоомын ажиллагаа” стандартын 6.7.1-д заасны дагуу сорил хийж үзэхэд холбох хэсгийн эд ангийн гадаад голч нь 50 мм-ээс хэтэрсэн байвал тоглоомын шаардлага хангахгүй гэж үзнэ.



Боолт нь эргэний түвшнээс илүү гарсан урах, орооцолдох аюул учирч болзошгүй аюулын жишээ

Зураг 3. Гогодох эрсдэлийн жишээ

гадна талд байрлуулан хэрэглэдэг савлуур, гулсуур болон түүнтэй төсөөтэй тоглоомын ажиллагаа” стандартын 6.6-д заасны дагуу шалгахад тээглэхгүй байх шаардлагатай.

жич: Цагариг бүтэцтэй элементийг хэрэглэхэд хувцас, үс орооцолдохоос сэргийлж, онцгойлон анхаарах хэрэгтэй.

Тоглоомын талбайн тоноглолын эрэг, шураг, боолтын толгой гэх мэт ил гарсан бэхэлгээг хүүхдийн хувцас гогодож, урагдахаас сэргийлж хэт том хийж болохгүй.

Уяа

Хүрэм, цамцны гэх мэт дээгүүр өмсөх хувцасны гаднах уяа, тоглоомын талбайн төхөөрөмжид орооцолдож боомилох замаар үхэлд хүргэх эрсдэлтэй.

Энэ эрсдэлээс сэргийлэхийн тулд

Хүүхдүүд гоёл чимэглэл, уяатай хүрэм, цамц, хоорондоо уяагаар холбосон бээлий гэх мэт уяатай дээгүүр өмсдөг хувцастай тоглоомын талбайн төхөөрөмж дээр тоглож болохгүй.

Тоглоомын талбайн төхөөрөмж дээр уяа, нохойны олс гэх мэт зүйлүүд байвал хүүхдүүд боомилох замаар үхэлд хүрэх эрсдэлтэй тул тоглохоос өмнө хураах хэрэгтэй.

Хоёр талдаа бэхлэгдээгүй олс бүхий тоног төхөөрөмжөөс зайлсхийх хэрэгтэй.

Аюул учрах магадлал өндөртэй гулсуур эсвэл бусад тоглоомын төхөөрөмж дээр дараах тэмдэг байна.



Зураг 4. Орооцолдох эрсдэлээс сэргийлэх тэмдэг

Толгой тээглэх эрсдэл

Толгой тээглэх нөхцөл байдалд боомилох, үхэлд хүргэх аюултай учир онцгой анхаарах шаардлагатай.

Хүүхэд онгорхой хэсгээр хөл эсвэл толгойн аль нэгээр эхэлж ороод гацах магадлалтай байдаг.


Хөдөлгөөнт тоглоом нь толгой, хөлийн аль нэг нь цухуйх эхний агшинд хүзүү, толгой тээгэлдэх онгорхойгүй, аюулгүй байхаар зохион бүтээгдсэн байна.

Жишээ: Аюултай нөхцөл үүсгэж болохуйц тээглүүр:

- Хэрэглэгч эхлээд толгойгоо эсвэл хөлөө гарган гулгах битүү цагариг хэлбэрийн нүхтэй гулсуур
- Хагас онгорхой эсвэл V хэлбэрийн нүхтэй гулсуур
- Хөдөлгөөн эсвэл түлхэлтээр онгойдог нүхтэй гулсуур


Материал сонгохдоо, тоглоомоор тоглох явцад түүнийг хийсэн материалын гэмтлийн улмаас тээглэх аюул үүсгэж болох эсэхийг анхаарах хэрэгтэй.

Зөөлөн эд анги (олс) нүхтэй давхцаж болохгүй. Бүтэн тойрог нүх, хагас тойрог, V хэлбэрийн нүх нь MNS ISO 8124-4 : 2011 “Орон сууцны дотор гадна талд байрлуулан хэрэглэдэг савлуур, гулсуур болон түүнтэй төсөөтэй тоглоомын ажиллагаа” стандартын 6.5.1, 6.5.2 шаардлагыг тус тус хангасан байна.



Хашлаганы доогуур болон хашлаганы босоо шугамын хооронд орооцолдох жишээ

Зураг 5. Тээглэх эрсдэл



Зураг 6. 55°-с бага өнцөгтэй V хэлбэрийн нүхэнд гацах эрсдэлийн жишээ

Завсар зай

MNS ISO 8124-4 : 2011 “Орон сууцны дотор гадна талд байрлуулан хэрэглэдэг савлуур, гулсуур болон түүнтэй төсөөтэй тоглоомын ажиллагаа” стандартын 4.4.2, 4.4.3, 4.4.4 дэх шаардлагыг хангасан байна.

Хурц өнцөг, булан, ирмэгээс учрах эрсдэл

Тоглоомын талбайн аль ч хэсэгт хурц үзүүр, булан эсвэл ирмэг хүүхдийн арьсыг урж, зүсэх аюултай тул байж болохгүй. Осол гэмтэх эрсдэлээс урьдчилан сэргийлэхийн тулд:

- Газарт бэхлэгдээгүй нээлттэй хоолойг зориулалтын зөвхөн тусгай багажаар авагддаг тагаар таглагдсан байх ёстой.
- Модны эд анги нь гөлгөр байх ёстой.
- Тоглоомын булан, зах ирмэг нь дугуй байх хэрэгтэй.
- Хөдөлгөөнтэй хэсгийн ил харагдах ирмэг, булан нь 3 мм-ээс багагүй радиустай байна. Энэ нь 1000 г эсвэл түүнээс бага жинтэй савлуурын элементэд хамаарахгүй бөгөөд савлуурын ирмэг, булан нь дугуй байх шаардлагатай.
- Ямар нэгэн ил харагдах холбох хэрэгсэл нь 76 мм байвал MNS ISO 8124-4 : 2011 “Орон сууцны дотор гадна талд байрлуулан хэрэглэдэг савлуур, гулсуур болон түүнтэй төсөөтэй тоглоомын ажиллагаа” стандартын 6.7.2-т заасан багажийн сорилын шаардлага хангах ба эхлэх хэсгээс 3 мм түүнээс дээж өндөрт бэхлэгдсэн хэсэг нь хурц өнцөг үүсгээгүй эсвэл

перпендикуляраар холбогдоогүй байх хэрэгтэй

- Ган бүслүүртэй радиалуудыг тоглоомын талбайн тоног төхөөрөмж болгон ашигладаг бол үүнийг баталгаажуулахын тулд тэдгээрийг сайтар шалгаж байх хэрэгтэй ил гарсан утас байхгүй байна.

Осол гэмтлээс урьдчилан сэргийлэх зорилгоор тоглоомын төхөөрөмжид тогтмол үзлэг, шалгалт хийх ёстой.

Орооцолдох эрсдэл

Тоглоомын талбай дээрх хүүхдүүд кабель, цахилгааны утас, олс, эсвэл бусад уян хатан хэсгүүдэд бүдрэх ба тээгэлдэх эрсдэлтэй. Ослын аюулаас урьдчилан сэргийлэхийн тулд дараах арга хэмжээг авна:

- Ачаалал ихтэй замаас хол байх ёстой.
- Эргэн тойрны тоглоом болон гадаргуугаас ялгарах тод өнгөтэй байх ёстой.
- Өөрөө өөртэйгөө гогцоорох, бусад олс, гинж, уяатай орооцолдох, 13 см-с бага гогцоо үүсгэж болохгүй,
- Уян олс, гинж эсвэл оосрын 2 талын төгсгөл нь бэхлэгдсэн байх ёстой бөгөөд энэ нь олс, гинж эсвэл оосор эргэж мушгиран 130 мм түүнээс дээш голчтой гогцоо үүсэхээс сэргийлдэг.

Савлуур болон авирдаг торонд энэхүү шаардлага хамаарахгүй бөгөөд MNS ISO 8124-4 : 2011 “Орон сууцны дотор гадна талд байрлуулан хэрэглэдэг савлуур, гулсуур болон түүнтэй төсөөтэй тоглоомын ажиллагаа” стандартын шаардлагыг хангасан байна.

Тэнцвэр алдах эрсдэл

Хүүхдийн тоглоомын талбайд хүүхэд тэнцвэрээ алдаж унах эрсдэлээс бүрэн хамгаалагдсан байх ёстой.

Тоглоомын төхөөрөмж дээр тэнцвэр алдах (бүдэрч эсвэл хий гишгэж унах) аюул нь ихэвчлэн тоног төхөөрөмжийн бэхэлгээ болон Дундрах-дүүргэх гадаргын материалыг хязгаарлагчаас тохиолдох магадлалтай. Иймд дараах шаардлагыг хангасан байна.

- Тоглоомын төхөөрөмжийн бэхэлгээний бетон суурь хавтан, хөндлөн хоолой гэх мэтийг хамгаалалтын гадаргуугийн доор байрлуулна. Энэ нь мөн хүүхдүүд ил гарсан суурийн дээр унаж гэмтэл авахаас урьдчилан сэргийлэх болно.

- Тоног төхөөрөмжийн өнгө газрын хамгаалалтын бүрхүүлийн өнгөнөөс эрс ялгаатай байвал илүү тод ялгарч харагдах болно.
- Дундрах-дүүргэх гадаргын материалыг хязгаарлагч нь маш сайн харагдахаар байх.
- Аливаа налууугийн өөрчлөлт нь илэрхий байх шаардлагатай.

Хуучин дугуй

Хэрэглэсэн автомашины болон ачааны машины дугуйг ихэвчлэн тоглоомын талбайн төхөөрөмж болгон ашигладаг, жишээлбэл савлуурын сандал, хана руу авирагч, дүүжин даажингийн доор зөөллөх зэрэг аюулгүй ажиллагааны бүтээгдэхүүн болгон ашигладаг.

Дугуйг ашиглахдаа

- Дугуйны ган/төмөр бүслүүр ил гарсан эсэхийг ойр ойрхон шалгах хэрэгтэй.
- Дугуйн дотор ус, хог гэх мэт цугларсан эсэхийг шалгах
- Дугуйг хэрчиж хийсэн материалыг ашиглахдаа төмөр/металл бүрэн цэвэрлэгдсэн эсэхийг шалгах хэрэгтэй.

Чөлөөт уналтын өндөр

Тавцангийн дээд хэсгээс гадаргуу хүртэлх зай.

- Газрын гадаргуугаас 760 мм түүнээс дээш өргөгдсөн тоглоомын зогсох, суух зориулалттай тавцан нь бүх талаараа хаалттай байх шаардлагатай.
- Гулсуур, авирах хүрээ, болон шатны хаалт нь дундаа онгорхой нүхтэй байж болно.
- Газрын гадаргуугаас дээш 760 мм-1000 мм өргөгдсөн тавцангийн хаалт нь 630 мм-ээс багагүй өндөртэй байна.
- Газрын гадаргуугаас дээшээ 1000 мм-1830 мм өргөгдсөн тавцангийн хаалтын өндөр 720 мм-ээс багагүй байна.

- Газрын гадаргуугаас дээшээ 1830 мм дээш өргөгдсөн тавцангийн хаалтын өндөр 840 мм-ээс багагүй байна.
- Газрын гадаргуугаас 760 мм-1000 мм өргөгдсөн тавцангийн хаалтын дундах нүх буюу нээлттэй хэсгийн дээд хэмжээ нь босоо шугамын дагуу 610 мм байна.
- Газрын гадаргуугаас 1000 мм-ээс дээш өндөрт байрлах тавцангийн хаалт нь авирч гарах магадлалыг бууруулдаг. Тавцангийн гадаргуу болон хаалтын хооронд эсвэл хаалтын дундах нүх нь MNS ISO 8124-4 : 2011 “Орон сууцны дотор гадна талд байрлуулан хэрэглэдэг савлуур, гулсуур болон түүнтэй төсөөтэй тоглоомын ажиллагаа” стандартын 6.5.1, 6.5.2 шаардлагыг тус тус хангасан байна.
- Дээд талын гадаргуу нь тэгш бус загвараар хийгдсэн тохиолдолд хаалтын хамгийн бага өндөр нь 200 мм \pm 5 мм байх шаардлагатай. Хаалтын ёроол хэсэг болон тавцангийн хоорондын босоо тэнхлэгийн дагуух зайг хэмжих хэрэгтэй. Энэ зай нь MNS ISO 8124 стандартад заасан хамгийн бага өндрөөс хэтрэхгүй байх ёстой.

Жич: Гулсуурын тусгай шаардлагыг дагаж мөрдөнө (4.6.2, 4.6.3-г үз).

- MNS ISO 8124-4 : 2011 “Орон сууцны доторгаднаталдбайрлууланхэрэглэдэг савлуур, гулсуур болон түүнтэй төсөөтэй тоглоомын ажиллагаа” стандартын 6.5.1, 6.5.2 шаардлагыг тус тус хангасан байна.6,3-д заасны дагуу шалгахад хаалт болон шатны бариулын аль ч хэсэг нурж унах ёсгүй бөгөөд сорилыг даваагүй тохиолдолд стандартын шаардлага хангаагүй гэж үзнэ.

БҮЛЭГ 4. АШИГЛАЛТ, АРЧИЛГАА ҮЙЛЧИЛГЭЭ

Тоглоомын талбайн арчлалт хангалтгүй байх нь осол гэмтэл гарах үндэс болдог. Тоглоом нь хэрэглэхэд зохимжтой, аюулгүй байх нь үйлдвэрлэгчээс өгсөн зааврын дагуу тогтмол хугацаанд хийгдэх хяналт, засвар үйлчилгээнээс хамаардаг. Хэрвээ үйлдвэрлэгчээс өгсөн заавар байхгүй бол тодорхой хуваарийн дагуу эсвэл урьдчилсан байдлаар хяналт, засвар үйлчилгээг хийнэ. Ачаалалтай ашиглагддаг тоглоомын хяналт, засвар үйлчилгээг байнга хийх шаардлагатай.

Засвар үйлчилгээний хяналт

Тоглоомын талбай бүр засвар үйлчилгээний иж бүрэн хөтөлбөртэй байх ёстой. Тоглоомын талбайн нийт талбай, тоглоомууд нь элэгдэл эвдрэлээс шалтгаалан осол гэмтэл учруулахаар байгаа эсэх нь шалгагдах ёстой. Хүснэгт 6-д Тоглоомын талбайн ашиглалтыг тогтмол хянах “Шалгах асуулт”-г үзүүлэв.

Хүснэгт 6. Байнгын хяналт, Засвар үйлчилгээний асуудал

<input type="checkbox"/>	Боолт нь гээгдсэн, таглаа нь байхгүй, хагарсан, хугарсан, эмтэрсэн гэх мэт Эвдэрсэн тоглоом
<input type="checkbox"/>	Хагарсан шил болон бусад хог
<input type="checkbox"/>	Хуванцар хэрэгслийн хагархай
<input type="checkbox"/>	Мултарсан зангуу бэхэлгээ
<input type="checkbox"/>	Эрсдэл учруулахуйц, аюултай эвдэрсэн зүйлс
<input type="checkbox"/>	Шавьж хорхойд идэгдсэн
<input type="checkbox"/>	Талбайн гадаргын бүрэн бүтэн байдал
<input type="checkbox"/>	Нөхөгдөөгүй элс, хайрган талбай (4.3-г харна уу)
<input type="checkbox"/>	Нүх, ховхорсон халцарсан гадаргуу, нэгэн жигд бус гадаргуу
<input type="checkbox"/>	Хэрэглэгчийн өөрчлөлт(Уяа, олс, тоглоомын хэмжээг өөрчилсөн)
<input type="checkbox"/>	Нурааж сүйтгэх
<input type="checkbox"/>	Элэгдсэн, суларсан, гэмтсэн, гээгдсэн хэсгүүд
<input type="checkbox"/>	Модны хугархай,
<input type="checkbox"/>	Зэвэрсэн төмөр
<input type="checkbox"/>	Ялзрал

Засвар

Хяналт нь дангаараа иж бүрэн арчилгааны хөтөлбөр болж чадахгүй. Хяналтын үед илэрсэн асуудал нь нэн даруй засагдах ёстой.

- Үйлдвэрлэгчийн зааврын дагуу бүх засвар үйлчилгээ хийгдэх ёстой.
- Аливаа тасрах гэж байгаа уяа олсыг нэн даруй солих эсвэл зайлуулах хэрэгтэй
- Тоглоомыг хянах давтамж нь түүний төрөл, насжилт, хэрэглээний ачаалал, цаг уурын нөхцөл байдлаас хамаарна.

Элэгдсэн гадаргуугийн засвар

Элс хайрга гэх мэт нөхөн сэргээж байх шаардлагатай гадаргуу нь тусгай арчилгаа шаарддаг. Өндөр ачаалалтай нийтийн тоглоомын талбайд ойр ойрхон гадаргуугийн хяналт хийж байх шаардлагатай бөгөөд гулсуур, савлуур зэрэг тоглоомын гадаргууг байнга нөхөн сэргээж байх шаардлагатай.

БҮЛЭГ 5. ТОГЛООМЫН ТАЛБАЙН ИЖ БҮРДЭЛ

Тавцан, бариул, хамгаалалтын хашлага

Тавцан

Тавцангууд хавтгай тэгш гадаргуу байна. $\pm 2^0$ налуу байж болно.

Тавцан нь ус тогтохооргүй байх ба ус зайлуулах гаргалгаатай байна.

Хог хаягдал цуглахааргүй байна.

06 сартайгаас-23 сартай хүүхдэд зориулсан тавцан газрын гадаргаас 30 см-ээс ихгүй байна.

Шаталсан тавцан

Зарим нийлмэл бүтэцтэй тоглоомууд үелсэн болон давхарласан тавцангуудтай байдаг учраас хүүхэд шат ашиглахгүй өндөрт гарсан байдаг. Тавцан хоорондын шатлалын өндөр нь 06 сараас 23 сартай хүүхдийн тоглоомд 18 см, 2-5 настайд 30 см, сургуулийн насны хүүхдэд 80 см-ээс ихгүй байна.

Хашлагатай тавцангуудын хаалт нь тээглэх эрсдэлээс хамгаалж дараах арга хэмжээг авна.

- 06 сараас 23 сартай хүүхдийн тоглоом: 18 см бага өндөрт байрлах тавцангийн хамгаалалтын сараалжийн алхам 7,5 см-ээм бага байхаар хийнэ
- 2-5 настай хүүхдийн тоглоом: 22 см-ээс дээш өндөрт байрлах чөлөөт уналтын өндөр 75 см-ээс их тавцангийн хамгаалалтын сараалжийн зай 9 см-ээс ихгүй байхаар хийнэ.
- 5-12 настай хүүхдийн тоглоом: 23 см-ээс дээш өндөрт байрлах чөлөөт уналтын өндөр 120 см-ээс их тавцангийн хамгаалалтын сараалжийн зай 9 см-ээс ихгүй байхаар хийнэ.

Бариул, хамгаалалтын хаалт

Бариул болон хамгаалалтын хаалт нь налуу гадаргуугаас унах магадлалыг бууруулдаг.

Хамгаалалтын хаалт нь бариулаас илүү хамгаалалт болдог учир хүүхдүүдийг бариулын завсар эсвэл дээгүүр нь авирахаас сэргийлдэг.

Бариул, хамгаалалтын хаалт нь дараах шаардлагыг хангах ёстой:

- Налуу гадаргууг бүхэлд нь хүрээлэх
- Оролт, гаралтаас бусад хэсэгт хөндлөн бариулгүй нээлттэй хэсэг нь 40 см-ээс хэтрэхгүй байх
- Тавцангаас санамсаргүй унахаас сэргийлэх
- Тээглэх эрсдэлээс сэргийлэх
- Хараа хяналтыг хөнгөвчлөх

Жишээлбэл: Налуу тавцан, явган зам, газарт буух хэсэг, шат, шилжилтийн гадаргуу нь хамгаалалтын бариул болон хаалттай байх хэрэгтэй. Бага насны хүүхдүүд биеийн тэнцвэрээ бүрэн олоогүй байдаг учир санамсаргүйгээр унах эрсдэл илүү байдаг. 06 сараас 23 сартай хүүхдийн тоглоомууд 45 см-ээс өндөрт байрлах налуу гадаргуу нь заавал хамгаалалтын хаалттай байна.

Бариул болон хамгаалалтын хашлага нь хамгийн өндөр хүүхэд давж унахааргүй өндөртэй байх шаардлагатай. Хашлаганы доод ирмэг нь хамгийн жижиг хүүхэд доогуур нь гарахааргүй доор байна. Бариул нь хамгийн жоохон хүүхэд давж унахааргүй хэмжээнд байрлана. Бариул болон хамгаалалтын хашлаганы шаардлагыг хүснэгт 7-д үзүүлэв. Авирдаг тоглоом, 06-23 сартай хүүхдийн 18 см хүртэлх өндөртэй тавцан, сургуулийн өмнөх насны хүүхдийн 50 см хүртэлх өндөртэй тавцан, сургуулийн насны хүүхдийн 150 см хүртэлх өндөртэй тавцан зэрэг үндсэн зориулалт нь бариул, хамгаалалтын хашлага шаардлагагүй тоглоомд энэ шаардлага тавигдахгүй болно.

Тоглоомын оролтын хэсэг (Access method)


Тоглоомын талбайн төхөөрөмж рүү нэвтрэх олон арга байдаг: налуу зам, энгийн шат, авирдаг шат гэх мэт. Тоглоомын төхөөрөмж рүү бас авирдаг тор, дугуйн шатаар авирч гарж болно (7-р зургийг үз).

Хүүхэд хөгжихийн хэрээр илүү тэнцвэртэй болдог тул тоглоом руу нэвтрэх аргыг насны ангилалд үндэслэн сонгох нь чухал юм.

Хүснэгт 8-д насны ангилал бүрд хамгийн тохиромжтой түгээмэл нэвтрэх арга харуулав. 180 см дээш өндөртэй тоглоом руу нэвтрэхэд (гулсуураас бусад) завсрын амрах тавцангаар хангах ёстой. Ингэснээр хүүхэд түр зогсоож, дээшээ явахаа үргэлжлүүлэх эсвэл буух арга зам олох эсэхээ шийдэх боломж гарна. Тоглоом руу орох хэсэг нь хэцүү байх тусам гарах хэсэг амархан байх нь их чухал.

Хүснэгт 7. Бариул болон хамгаалалтын хашлаганы шаардлага

	Бариул	Хамгаалалтын хашлага
Тавцангаас санамсаргүй унаж гэмтэхээс хамгаална.	Тийм	Тийм
Давж авирахыг хориглох	Үгүй	Тийм
Авирахаас хамгаалдаг	Үгүй	Тийм
06 сараас 23 сартай хүүхэд		
A Тавцангаас дээд ирмэг хүртэлх зай	Хэмжээ заахгүй	A = 60 см-ээс их
B Тавцангаас доод ирмэг хүртэлх зай	Хэмжээ заахгүй	B < 7.5 см
H Тавцангийн чөлөөт уналтын өндөр H байх үед шаардлагатай	Хэмжээ заахгүй	H = 40 см-ээс их
Сургуулийн өмнөх нас 2-6 настай		
A Тавцангаас дээд ирмэг хүртэлх зай	A = 73 см-ээс их	A = 73 см-ээс их
B Тавцангаас доод ирмэг хүртэлх зай	22 см < B ≤ 58 см	B < 9 см
H Тавцангийн чөлөөт уналтын өндөр H байх үед шаардлагатай	50 см < H ≤ 75 см	H > 75 см
Сургуулийн нас 6-12 настай		
A Тавцангаас дээд ирмэг хүртэлх зай	A = 95 см-ээс их	A = 95 см-ээс их
B Тавцангаас доод ирмэг хүртэлх зай	22 см < B ≤ 70 см	B < 9 см
H Тавцангийн чөлөөт уналтын өндөр H байх үед шаардлагатай	75 см < H ≤ 120 см	H > 120 см



Зураг 7. Тоглоом руу ороход илүү чадвар шаардсан орох хэсэг

Хүснэгт 8. Тохиромжтой түгээмэл нэвтрэх арга насны ангиллаар

Орох арга	Зураг	Сорилтын түвшин	Насны ангилал
Налуу гарц		Маш хялбар	Бүх насны хүүхдүүд
Хамгаалалтын хашлагатай шат		Хялбар	Бүх насны хүүхдүүд
Хамгаалалтын хашлагатай спираль шат		Дунд зэрэг	Бүх насны хүүхдүүд*
Гишгүүртэй, бариултай авирах шат		Дунд зэрэг	15 сартай болон түүнээс дээш нас
Авирах хүрээ		Дунд зэрэг	Сургуулийн өмнөх ба түүнээс дээш нас
Гүдгэр авирах хүрээ		Хэцүү	Сургуулийн өмнөх ба түүнээс дээш нас
Уян авирах төхөөрөмж		Хэцүү	Сургуулийн өмнөх ба түүнээс дээш нас

- 06 сартайгаас 23 сартай хүүхдүүд тоглох тохиолдолд орц гарц нь хялбар байх шаардлагатай

Хүснэгт 9. Тохиромжтой түгээмэл нэвтрэх төхөөрөмжид тавигдах шаардлага

Орц, гарцын төрөл	06 сартайгаас 23 сартай	Сургуулийн өмнөх нас (2-5 нас)	Сургуулийн нас (6-12 нас)
Налуу гарц			
Налуу (Босоо:Хөндлөн)	< 1:8	≤ 1:8	≤ 1:8
Өргөн (Дан)	≥ 48 см	≥ 30 см	≥ 40 см
Өргөн (Давхар)	≥ 75 см	≥ 75 см	≥ 90 см
Хамгаалалтын хашлагатай шат			
Налуу	≤ 35°	< 50°	< 50°
Гишгүүрийн өргөн (Дан)	30-53 см	≥ 30 см	≥ 40 см
Гишгүүрийн өргөн (Давхар)	≥ 75 см	≥ 75 см	≥ 90 см
Гишгүүрийн гүн (Нээлттэй)	Зохимжгүй	≥ 18 см	≥ 20 см
Гишгүүрийн гүн (хаалттай)	≥ 20 см	≥ 18 см	≥ 20 см
Гишгүүрийн өндөр	≤ 18 см	≤ 23 см	≤ 30 см
Гишгүүртэй авирах шат			
Налуу	35° ≤ 65°	50° -75°	50° -75°
Гишгүүрийн өргөн (Дан)	30-53 см	30-53 см	≥ 40 см
Гишгүүрийн өргөн (Давхар)	Зохимжгүй	Зохимжгүй	≥ 90 см
Гишгүүрийн гүн (Нээлттэй)	Зохимжгүй	≥ 18 см	≥ 7.5 см
Гишгүүрийн гүн (хаалттай)	20 см	≥ 18 см	≥ 15 см
Гишгүүрийн өндөр	>13 см ба ≤18 см	≤ 23 см	≤ 30 см
Авирах хүрээ			
Налуу	Зохимжгүй	75-90°	75-90°
Хүрээний өргөн	Зохимжгүй	≥ 30 см	≥ 40 см
Гишгүүрийн өндөр	Зохимжгүй	≤ 30 см	≤ 30 см
Хүрээний диаметр	Зохимжгүй	2.4-3.9	2.4-3.9
*Оролтын хэсгийн нээлттэй хэсгүүд нь гогодох эрсдэлээс хамгаалсан байх шаардлагатай			

Тоглоомын үндсэн төрлүүд

Тэнцвэрийн тоглоом (Balance beams)

Тэнцвэрийн тоглоом нь 06 сараас 23 сартай хүүхдэд зориулагдахгүй бөгөөд сургуулийн

өмнөх насны хүүхдэд чөлөөт уналтын өндөр нь 30 см, сургуулийн насны хүүхдэд 38 см-ээс ихгүй байна.



Зураг 8. Тэнцвэрийн тоглоом

Чөлөөт уналтын өндөр нь:

Тэнцвэрийн тоглоомын чөлөөт уналтын өндөр нь алхаж буй гадаргуугийн дээд хэсэг болон хамгаалагдсан гадаргуу хүртэлх зай.

Авирах болон зүүгдэх тоглоом

Гүдгэр авирах хүрээ



Бөмбөгөр авирах хүрээ



Хөндлөн авирах хүрээ



Хөндлөн дамжих цагираг

Авирдаг тоглоом нь тоглоомын талбайн бусад тоглоомтой харьцуулахад илүү бие бялдрыг хөгжүүлэхэд чиглэсэн байдаг. Энэ төрлийн тоглоомоор тоглохдоо (дээш авирах, хөдлөх) гараа ашиглах шаардлагатай байдаг.

Авирах тоглоом нь дараах төрлүүд байдаг ч үүгээр хязгаарлагдахгүй.

- Нуман хэлбэртэй
- Бөмбөгөр
- Уян (Ихэвчлэн гинж эсвэл тор)
- Зэрэгцээ багана
- Гулгадаг шон
- Спираль
- Биеэс дээгүүрх тоглоом (Хөндлөн шат, хөндлөн цагариг, track ride).

Сургуулийн насны хүүхдүүд сургуулийн өмнөх насны хүүхдүүдтэй харьцуулахад авирах болон биеэс дээгүүрх тоглоомоор тоглох чадвар илүү байдаг.

4-5 наснаас эхлэн хүүхдүүд авирдаг тоглоомоор тоглох чадвартай болж эхэлдэг.

Анхаарах зүйлс

Нийлмэл бүтэцтэй тоглоомын бүрэлдэхүүнд авирах тоглоом орсон бол зэргэлдээх тоглоомын хөдөлгөөний урсгалтай тоглоомын шаардлага нийцсэн байх ёстой.

Чөлөөт уналтын өндөр нь:

Энэ хэсэгт өөрөөр заагаагүй бол авирах тоглоомын чөлөөт уналтын өндөр нь тоглоомын хамгийн дээд хэсэг болон хамгаалалтын гадаргуу хүртэлх зай байна.

Авирах тоглоом нь нийлмэл бүтэцтэй тоглоомын бүрэлдэхүүнд орсон бол чөлөөт уналтын өндөр нь авирах тоглоомын хэсгийн хамгийн дээд хэсэг болон хамгаалалтын гадаргуу хүртэлх зай байна.

Биеэс дээр байрлах тоглоомын Чөлөөт уналтын өндөр нь тоглоомын хамгийн дээд хэсэг болон хамгаалалтын гадаргуу хүртэлх зай байна.

Авирах шатны гишгүүр

Зарим оролтын төрлүүд нь авирах тоглоом гэж тооцогддог.


Авирах гишгүүр нь ерөнхийдөө дугуй хэлбэртэй байх хэрэгтэй.

Бүх гишгүүрүүд нь холбирохоос урьдчилан сэргийлэх зорилгоор бэхлэгдсэн байх шаардлагатай.

Ашиглалтын бүс

Ашиглалтын бүс нь тоглоомын эргэн тойрон 1800 мм-ээс их байна. 9-р зураг

Авирдаг тоглоомын ашиглалтын бүс нь зэргэлдээх тоглоомын ашиглалтын бүстэй давхардаж болно. Гэхдээ тоглоом хооронд хамгийн багадаа 1800 мм зайтай байх бөгөөд зэргэлдээх тоглоомын өндөр 75 см-ээс өндөргүй байна эсвэл 75 см-ээс өндөр тоглоом бол хоорондох зай 2700 мм их байх шаардлагатай.



Зураг 9. Нуман хэлбэртэй авирах тоглоомын ашиглалтын бүс


Нуман хэлбэртэй авирах тоглоом

Нуман хэлбэртэй авирах тоглоом нь гүдгэр хажуугийн тулгууруудад бэхлэгдсэн гишгүүрүүдээс бүрддэг. Эдгээр нь дангаараа эсвэл бусад тоглоом руу орох хэсэг болгон ашиглагддаг. Зураг 10, 11.


Сургуулийн өмнөх насны хүүхдийн тоглоомын орох хэсэг нь зөвхөн нуман хэлбэртэй авирах тоглоом байж болохгүй.

Дангаараа байхаар хийгдсэн нуман хэлбэртэй авирах тоглоом 06-23 сартай хүүхдэд зохимжгүй.

Гишгүүрийн диаметр болон гишгүүр хоорондын зайн хэмжээнд хүснэгт 6-д заасан гишгүүртэй(rung ladder) -д тавигдах шаардлагыг мөрдөнө.



Зураг 10. Нуман хэлбэртэй авирах тоглоом



Зураг 11. Нуман хэлбэртэй авирах тоглоомон орох хэсэг

Уян авирах тоглоом

Олс, татлага, гинж, хаймар дугуй зэргийг холбож сүлжин авирах төхөөрөмжид ашигладаг. Уян бүтэцтэй авирах тоглоом нь хатуу бүтэцтэй тоглоом шиг тогтвортой биш учир илүү их биеийн тэнцвэрийн чадвар шаарддаг.

Олс, татлага, гинж нь 2 эсвэл 3 хэмжээстэй торлосон хэлбэртэй байдаг. Зураг 12




Зураг 12. Уян авирах тоглоом

Хаймар дугуйн бүтэц нь дугуйг дугуйтай нь холбож налуу тор үүсгэн дэвсэх, эсвэл гинж болон бусад холбох хэрэгслээр холбож хийнэ. Уян авирах тоглоомын эхлэл болон төгсгөлийн хэсэг сайтар бэхлэгдсэн байх шаардлагатай. Хэрвээ газарт бэхлэгдэж байгаа бол бэхэлгээ нь газрын гадаргуугаас доош суурилуулах бөгөөд хамгаалалтын гадаргуугаар хучигдсан байна.

Олс, таталга, гинж, дугуйн холбоосыг сайтар бэхэлсэн байна.

6-с доош насны хүүхдийн тоглоомын орох хэсэгт уян авирах тоглоомыг хэрэглэж болохгүй. Мөн бие даасан уян тоглоомоор 6-доош насны хүүхэд тоглож болохгүй.

Хөндлөн болон босоо хэсгийн хоорондох зай нь тээглэх эрсдэл учруулахааргүй байна. Торон бүтцийн торлол хоорондын зай 43 см-ээс бага эсвэл 71 см-ээс их байна. Зураг 13



Зураг 13. Уян авирах тоглоомын орооцолдох эрсдэл

Хэвтээ дамжих хүрээ

Биеийн дээд хэсгийг хөгжүүлэх зориулалттай авирдаг тоглоомын нэг төрөл юм. Тоглоомын нэг захаас нөгөөг зах хүртэл хүүхдүүд зөвхөн гараараа дамжин тоглохоор загварчлагдсан. 4-өөс дээш насны хүүхэд энэхүү тоглоомоор тоглох чадвартай болсон байдаг учир 3-аас доош насны хүүхдэд зориулагдсан тоглоомын талбайд суурилуулах ёсгүй.

4-12 настай хүүхдэд зориулагдсан хэвтээ шатанд тавигдах шаардлагыг доор үзүүлэв.

Хэвтээ дамжих хүрээний эхний болон төгсгөлийн бариул нь өгсөх болон буухад зориулагдсан тавцан, болон авирах төхөөрөмжийн эгц дээр байж болохгүй.

Эхний бариулаас хэвтээ чигт байх зай 25 см-ээс ихгүй, тавцангийн эгц дээр байж болохгүй, Авирдаг тоглоомоос эхэлж байгаа бол 20 см-ээс их 25 см-ээс бага байна.

Зэрэгцээ бариулуудын хоорондох зай тээглэх эрсдэлээс хамгаалагдсан 23 см-ээс их байна. Сургуулийн өмнөх насны хүүхдэд зориулагдсан хэвтээ дамжих хүрээний бариулууд параллель, жигд зайтай байна.

Хэвтээ дамжих хүрээний өндөр (Тоглоомын хамгийн дээд хэсгийн атгах бариулын төвөөс хамгаалалтын гадарга хүртэлх зай.)-т тавигдах шаардлага:

4-5 настай хүүхдэд 150 см-ээс ихгүй, сургуулийн насны хүүхэд 210 см-ээс ихгүй байна.

Хэвтээ дамжих хүрээний гишгүүр хоорондын зай 4-5 настай хүүхдийнх 30 см ихгүй, сургуулийн насны хүүхдийнх 38 см ихгүй байна.

Тоглоомоос буух өндөр 4-5 настай хүүхдийнх 45 см-ээс ихгүй, сургуулийн насны хүүхдийнх 90 см-ээс ихгүй байна.

Хөндлөн дамжих цагариг

Хөндлөн дамжих цагариг нь хөндлөн шаттай адил хэрэглээтэй. Тиймээс 4-с дээш насны хүүхэд тоглох боломжтой. 3 ба түүнээс доош насны хүүхдэд зориулагдсан тоглоомын талбайд байрлуулахгүй. Доорх шаардлага нь 4-12 настай хүүхдийн тоглоомд тавигдана.

Хэвтээ дамжих цагариг эхний болон төгсгөлийн бариул нь өгсөх болон буухад зориулагдсан тавцан болон авирах төхөөрөмжийн эгц дээр байж болохгүй

Эхний бариулаас хэвтээ чигт байх зай 25 см-ээс ихгүй, тавцангийн эгц дээр байж болохгүй, Авирдаг тоглоомоос эхэлж байгаа бол 20 см-ээс их 25 см-ээс бага байна.

Хэвтээ шатны өндөр (Тоглоомын хамгийн дээд хэсгийн зурах төхөөрөмжийн төвөөс хамгаалалтын гадарга хүртэлх зай.)-т тавигдах шаардлага нь 4-5 настай хүүхдэд

150 см-ээс ихгүй, сургуулийн насны хүүхэд 210 см-ээс ихгүй байна.

Савладаг цагаригууд нь гинжээр бэхлэгдсэн байх ба 18 см-ээс ихгүй урттай байна.

Тоглоомоос буух өндөр 4-5 настай хүүхдийнх 45 см-ээс ихгүй, сургуулийн насны хүүхдийнх 90 см-с ихгүй байна.

Гулгадаг шургааг

Босоо гулгадаг шургааг нь бусад төрлийн авирах тоглоомоос илүү хүч чадал шаарддаг. Амжилттай гулгаж буухын тулд биеийн дээд хэсгийн болон тэнцвэрийн чадвар шаарддаг. Тоглоомоос гарах бусад аргаас өөр бөгөөд чиглэлээ өөрчлөх, зогсох боломжгүй учир хүүхэд санаагаа өөрчилж чадахгүй. Хүүхэд гулгаж эхэлсэн бол дуустал нь үргэлжлүүлэх чадвартай байх ёстой хэрвээ чадахгүй бол хүүхэд унана.

Зөвхөн сургуулийн насны хүүхдийн тоглоомд төлөвлөнө.

Гулгадаг шургааг нь жигд үргэлжилсэн байх ба хотгор, гүдгэр, холбоос байх ёсгүй.

Гулгах чиглэл өөрчлөгдөх ёсгүй

Гулгах шургааг бусад хэсгээс хэвтээ чиглэлд 45-50 см зайтай байх ёстой

Шургааг нь тавцангийн дээд түвшин болон гулгах аар хандах бүтцээс 150 см-ээс илүү өндрөөс эхэлнэ.

Гулгах шургаагийн диаметр 5 см-с илүүгүй байна.

Гулгах шургааг болон түүнд хандах бүтэц нь тодорхой байрлах ёстой бөгөөд доош гулгах үед бусад хөдөлгөөний урсгал нөлөөлөхөөргүй байна. Дээд талын хандах хэсэг нь зөвхөн нэг түвшинд байна.

Чөлөөт уналтын өндөр нь:

Чөлөөт уналтын өндөр нь хандах тавцан болон хамгаалалтын гадаргуу хоорондын зай байна. Хэрвээ тавцангаас хандахгүй бол гулгах шургаагийн дээд ирмэгээс 150 см доор байна.

Гулгадаг зам

Зориулалтын бариулаас барьж зориулалтын замаар зүүгдэж гулгадаг тоглоом. Гулгах явцдаа хүүхэд хөлөө дээш өргөх хэрэгтэй болдог. Энэ тоглоомыг тоглоход биеийн дээд хэсгийн чадвар шаардах бөгөөд гулгах явц саадгүй аюулгүй байна гэдэгт дүгнэлт хийх чадвартай байх ёстой.

Зөвхөн сургуулийн насны хүүхдийн тоглоомын талбайд төлөвлөнө.

Гулгаж эхлэхээс дуусах, газарт буух хүртэл ямар нэг саад байх ёсгүй.

Гулгах зам нь хоорондоо хамгийн багадаа 120 см зайтай байна.

Бариул нь гадаргаас 160-200 см-ын өндөрт байрлана.

Зууралтын шаардлагад зохих стандартыг мөрдөнө.

Хөдөлгөөнт хэсэгт ямар нэг уягдсан зүйл байх ёсгүй.

Өнхрөх хэсэг нь шахагдах, бяцлах, гэмтэх эрсдэлээс хамгаалах зорилгоор битүүлэгдсэн байна.

Чөлөөт уналтын өндөр нь:

Төхөөрөмжийн хамгийн өндөр хэсэг болон хамгаалалтын гадарга хүртэлх зай

Гүйдэг бөмбөрцөг

Гүйдэг бөмбөрцөг том хүүхдүүдэд зориулагдсан бөгөөд хүүхдийн тэнцвэрийн чадвар болон бие бялдрын тамирыг хөгжүүлдэг тоглоом юм. Хүүхдүүд бөмбөрцөг дээр зогсоод тэнцвэрээ олж гүйдэг тоглоом юм. Зураг 14



Зураг 14. Гүйдэг бөмбөрцөг

Зөвхөн сургуулийн насны хүүхдийн тоглоомын талбайд төлөвлөнө. 06-23 сартай болон сургуулийн өмнө насны хүүхдэд зориулагдаагүй. Энэ насны хүүхдүүд ерөнхийдөө гүйдэг бөмбөрцөг тоглох тэнцвэрийн болон бие бялдрын чадвар хөгжөөгүй байдаг.

Биеийн тэнцвэрийг олоход туслах бариултай байна. Бариул нь хүснэгт 9-д заасан шаардлагыг хангасан байна.

Бөмбөрцөгийн өндөр хамгаалалтын гадаргаас 45 см-ээс ихгүй байна.

Зэргэлдээ төлөвлөсөн тоглоомын гадаргуу 75 см-ээс өндөр биш бол тоглоом хоорондын зай 180 см-ээс их байх,

Зэргэлдээ төлөвлөсөн тоглоомын гадаргуу 75 см-ээс өндөр бол тоглоом хоорондын зай 275 см-ээс их байх,

Чөлөөт уналтын өндөр нь:

Чөлөөт уналтын өндөр нь бөмбөрцгийн хамгийн өндөр хэсэг болон хамгаалалтын гадаргын хоорондын зай.

Эргэдэг тавцан

Эргэдэг тавцан нь тоглоомын талбайд өргөн хэрэглэгддэг тоглоом юм. Тоглох хүүхдүүд тавцан дээр зогсох буюу сууж бусад хүүхдүүд эсвэл асран хамгаалагч тоглоомыг түлхэж эргүүлдэг тоглоом юм.

Мөн түүнчлэн эргэдэг тавцан эргэж байх үед хүүхдүүд тоглоом дээр суух эсвэл тоглоомоос буудаг.



Зураг 15. Эргэдэг тавцан


Эргэдэг тавцан нь хөдөлгөөнтэй байх үед бууж, сууж буй сургуулийн өмнөх насны хүүхдийн биед гэмтэл учруулах магадлалтай. Иймд энэ сургуулийн өмнө насны хүүхдэд асран хамгаалагчийн хяналтад эргэдэг тавцангаар тоглох хэрэгтэй.

06-23 сартай хүүхдэд зориулагдсан тоглоомын талбайд эргэдэг тавцанг төлөвлөхгүй.

Зогсох болон суух тавцангийн өндөр нь хамгийн ихдээ: хамгаалалтын гадаргаас сургуулийн өмнөх насны хүүхдэд 35 см-ээс дээш, сургуулийн насны хүүхдэд 45 см дээш өндөрт байна.

Эргэдэг тавцан нь жигд бөгөөд дугуй хэлбэртэй байна

Зөв дугуй биш эргэдэг тавцангийн хамгийн их болон хамгийн бага радиусын зөрүү 13 см-ээс ихгүй(Зураг 16) байна.



A= Эргэлддэг тоглоомын тэнхлэг
AB= Хамгийн бага радиус
AC= Хамгийн их радиус

AC ба AB-ийн хэмжээний зөрүү 51мм-ээс хэтрэхгүй

Зураг 16. Эргэдэг тавцангийн хамгийн их, хамгийн бага радиус

Тавцангийн хүрээний доод тал нь хамгаалалтын гадаргаас дээш 22 инчээс их зайд байрласан байна.

Тоглоомын доод хэсэгт байрлах механизм нь зүсэх, хавчих боломжгүй байх

Хүүхэд унаж аюулгүй байх хэрэгслээр хангагдсан байх ёстой бөгөөд хэрвээ бариул хийгдэж байгаа бол хүснэгт 9-ийн шаардлагыг хангасан байна.

Бариулыг оролцуулан тоглоомын аль ч хэсэг (төхөөрөмж) эргэх тавцангийн хүрээнээс гарах ёсгүй.

Эргэлдэх тавцанд ямар нэг хурц өнцөг, ирмэг байх ёсгүй.

Тавцангийн эргэлдэх хурд 30см/сек-ээс илүүгүй байх

Тавцангийн хөдөлгөөнд дээд доош дайвалзсан хөдөлгөөн байх ёсгүй.

Ашиглалтын бүс

Тоглоомын ашиглалтын бүс нь тоглоомын тавцангийн гадна талын ирмэгээс эргэн тойрон 1800 мм байна.

Зэргэлдээ тоглоомын ашиглалтын бүс нь бусад тоглоомынхтой давхарлахыг зөвшөөрсөн бөгөөд эргэх төхөөрөмжийн диаметр 50 см-ээс бага тохиолдолд эргэх тавцангийн ашиглалтын бүс давхардаж болно. Бусад тохиолдолд тоглоомын ашиглалтын бүс нь бусад тоглоомын ашиглалтын бүстэй давхардахгүй.

Чөлөөт уналтын өндөр нь:

Хүүхэд суух эсвэл зогсох тавцангийн өндрөөс хамгаалалтын гадарга хүртэлх зай.

Дүүжин даажин, Гулсуур (Slides), Савлуур нь MNS ISO 8124-4 : 2011 “Орон сууцны дотор гадна талд байрлуулан хэрэглэдэг савлуур, гулсуур болон түүнтэй төсөөтэй тоглоомын ажиллагаа” стандартын шаардлагыг тус тус хангасан байна.

ХАВСРАЛТ 1**Тоглоомын талбайн ашиглалтын шалгах хуудас**

<p>Гадаргуу</p> <ul style="list-style-type: none"> <input type="checkbox"/> Тоглоомын хамгаалалтын гадаргуу хангалттай. <ul style="list-style-type: none"> <input type="checkbox"/> Гадаргууг шинээр хийх / Нөхөн сэргээх <input type="checkbox"/> Гадаргуу элэгдээгүй. <ul style="list-style-type: none"> <input type="checkbox"/> Шинэчлэх <input type="checkbox"/> Бусад засвар, арчилгаа... <input type="checkbox"/> Дундрах-дүүргэх гадаргын материалд гадны биет, хог хаягдал байхгүй. <ul style="list-style-type: none"> <input type="checkbox"/> Хог хаягдлыг цэвэрлэх <input type="checkbox"/> Дундрах-дүүргэх гадарга нь дагтаршаагүй. <ul style="list-style-type: none"> <input type="checkbox"/> Гадаргууг суллах, сийрэгжүүлэх <input type="checkbox"/> Савлуур, гулсуур хөдөлгөөн ихтэй тоглоомын дундрах-дүүргэх гадаргуу тарж алга болоогүй <ul style="list-style-type: none"> <input type="checkbox"/> Гадаргууг суллах, сийрэгжүүлэх, нөхөх <p>Ус зайлуулах</p> <ul style="list-style-type: none"> <input type="checkbox"/> Тоглоомын талбай болон хөдөлгөөн ихтэй гулсуур, савлуур зэрэг тоглоомын доорх газар ус тунаж тогтохоос сэргийлэгдсэн <ul style="list-style-type: none"> <input type="checkbox"/> Ус зайлуулах суваг, шуудууг сайжруулах <input type="checkbox"/> Бусад засвар, арчилгаа... <p>Аюул</p> <ul style="list-style-type: none"> <input type="checkbox"/> Тоног төхөөрөмж дээр ямар нэг хурц үзүүр, ирмэг, булан байхгүй <input type="checkbox"/> Гээгдсэн, алга болсон, эвдэрсэн таглаа, холбогч байхгүй <input type="checkbox"/> Аюул учруулахуйц цухуйсан хэсэг байхгүй <input type="checkbox"/> s дэгээ, сэртгэр болт гэх мэт хувцас тээглэх эрсдэл учруулах зүйлс байхгүй <input type="checkbox"/> Нээлттэй хөдөлгөөнт хэсгүүд нь бяцлах, огтлох аюул учруулахгүй. <input type="checkbox"/> Тоглоомын суурь, зангуу, чулуу, үндэс болон бусад хөлд тээглэх аюул байхгүй 	<p>Тоног төхөөрөмжийн аюулгүй байдал</p> <ul style="list-style-type: none"> <input type="checkbox"/> Түгжээ, бэхэлгээ нь алдагдсан эсвэл элэглэж муудсан холбоос байхгүй <ul style="list-style-type: none"> <input type="checkbox"/> Түгжээс холбоосуудыг шинэчлэх <input type="checkbox"/> Бусад засвар, арчилгаа... <input type="checkbox"/> Савлуурын гогцоо, эргэдэг тавцангийн холхивч гэх мэт элэгдэж муудаагүй. <ul style="list-style-type: none"> <input type="checkbox"/> Эд ангийг шинэчлэх <input type="checkbox"/> Бусад засвар, арчилгаа... <p>Элэгдэл</p> <ul style="list-style-type: none"> <input type="checkbox"/> Тоног төхөөрөмж нь зэврээгүй, ялзраагүй, хагараагүй, цуураагүй (газартай холбогдож байгаа хэсгийг сайтар шалгах) <input type="checkbox"/> Тоног төхөөрөмжийн бүрдэл хэсэгт эвдэрсэн, алга болсон зүйл байхгүй. (барил, хашлага, хамгаалалтын сараалж, шат, гишгүүр гэх мэт) <input type="checkbox"/> Эвдэрсэн хашаа, сандал, тэмдэг байхгүй <input type="checkbox"/> Тоног төхөөрөмж найдвартай бэхлэгдсэн. <p>Будаг</p> <ul style="list-style-type: none"> <input type="checkbox"/> Тоног төхөөрөмжийн будаг нь хагарч, хууларч, ховхроогүй, <p>Тоглоомын талбайн ерөнхий арчилгаа</p> <ul style="list-style-type: none"> <input type="checkbox"/> Олс уяг зангидах, савлуурын суудлын дамнуурга дээгүүр давуулах гэх мэт хэрэглэгчийн хийсэн өөрчлөлт байхгүй. <ul style="list-style-type: none"> <input type="checkbox"/> Зангилааг тайлах, <input type="checkbox"/> Тоног төхөөрөмжийг хэвийн байдалд оруулах <input type="checkbox"/> Тоглоомын талбай нь модны мөчир, шил, лааз гэх мэт хог хаягдалгүй байна. <ul style="list-style-type: none"> <input type="checkbox"/> Тоглоомын талбайг цэвэрлэх <input type="checkbox"/> Хогийн сав бүрэн бүтэн байна. <ul style="list-style-type: none"> <input type="checkbox"/> Хогийн савыг шинэчлэх <input type="checkbox"/> Хогийн сав дүүрээгүй байна <ul style="list-style-type: none"> <input type="checkbox"/> Хогийн савыг цэвэрлэх
--	---

ХАВСРАЛТ 2

Байнгын хяналт болон ашиглалтын асуудал

- Боолт нь гээгдсэн, таг нь алга болсон, хагарсан гэх мэт эвдэрсэн тоног төхөөрөмж
- Хагархай шил болон бусад хог
- Алдагдсан бэхэлгээ
- Осолд гэмтэл учруулахуйц эвдэрхий зүйлс
- Шавьжнаас учрах хохирол
- Гадаргуугийн асуудал
- Дундрах-дүүргэх гадаргуугийн шилжилт
- Нүх, ховхорсон, овойсон хонхойсон гадаргуу
- Хэрэглэгчийн өөрчлөлт (олс уяа гинжийг зангидах, тоглоомын тохиргоог өөрчлөх гэх мэт)
- Нурааж сүйтгэх
- Элэгдсэн, гээгдсэн, эвдэрсэн, алга болсон тоног төхөөрөмжийн хэсэг
- Хугархай мод
- Зэвэрсэн төмөр
- Ялзрал

